



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/79

Сүхбаатар сум

Хурдан морины уралдаанч хүүхдийн амь  
нас, эрүүл мэндийг хамгаалах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах арга хэмжээний тухай" 57 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар батлагдсан "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ийн хавсралт 3 дугаар зүйлийн 3.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга болон аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Ганхуяг) нарт тус тус үүрэг болгосугай

3. Холбогдох хууль, тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлж, сурталчлан ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (П.Оюун) -д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/127 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.





1  
2  
3



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 1178


Сүхбаатар сум

### Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15.1, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мандал сумын 7 дугаар багийн шарын голын 38 тоотод оршин суугч Гомбын Баатарсүрэн нь сахарын өвчний улмаас Улаанбаатар хотын 1 дүгээр эмнэлэгт хөлний мэс засалд орж, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдан өвчнөөс шалтгаалан өртөг өндөртэй эм тариаг эмчилгээндээ хэрэглэж, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж зайлшгүй хэрэгцээт эм, тариа, уураг авахад санхүүгийн боломжгүйд хүрсэн амьдрал, санхүүгийн хүнд нөхцөл, өргөдлийг нь үндэслэн нэг удаагийн буцалтгүй тусламжийг хавсралтад зааснаар үзүүлсүгэй.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (О.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.



100  
2  
1

Борисовичи	Bozy
Адреса:	.....
Адрес:	.....